



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/31

Амардалай

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, 17.1, 17.1.1 дэх заалт, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/152 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, техникийн хяналтын улсын үзлэг тооллого явуулах, албан татвар, төлбөр хураамжийг бүрдүүлэх, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшилд байгаа бүх төрлийн тээврийн хэрэгслийг шинэчилсэн тоо бүртгэлд оруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч. Баярмаа (Төрийн сангийн албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Д. Ганчимэг (Татварын улсын байцаагч)

Гишүүд: Б. Азжаргал (Хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч)

Э. Лүндээжанцан (Сумын хэсгийн цагдаа, дэд ахлагч)

Б. Довуучий (1 дүгээр багийн Засаг дарга)

Г. Сосорбурам (2 дугаар багийн Засаг дарга)

Б. Баатарсүрэн (3 дугаар багийн Засаг дарга)

2.Комиссын гишүүд сум орон нутагт байгаа автомашин болон өөрөө явагч хэрэгслийн тооллого явуулахад шаардагдах бэлтгэл ажлыг хангаж, техникийн улсын үзлэг тооллогыг цаг хугацаанд нь явуулан, тайлан мэдээг холбогдох газарт тавьж шийдвэрлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ч. Баярмаа)-д даалгасугай.

ДАРГА

М. БАЯРСҮХ

432401061